



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот


**Төрийн албаны зөвлөлийн
Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх
салбар зөвлөлийн нарийн бичгийн
даргыг томилох тухай**

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, 4.3.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалт, мөн Зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/04 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Юурагийн Алтанцэцэгийг 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсугай.

2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ю.Алтанцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦОГОО